

МОНГОЛ ХЭЛ АЯЛГУУНЫ УЧИР

Ш.Лувсанвандан

1. Монгол угсаатан нь Төв Азийн асар уудам газар нутаг, жич Европын зарим хэсэгт таран сууж, зарим нь нүүдэл, зарим нь суурьшсан аж байдлыг эрхэлж, янз бүрийн соёлын нөлөөнд хуваагдан янз бүрийн улс, муж, хязгаарт багтаж, зарим нь хоорондоо нягт холбоотой, зарим нь үлэмж тасархай байдалтай явж ирсэн тул тэдний үг хэл ч мөн их бага боловч бие биеэсээ ялгавар бүхий олон нутгийн аялгуу, аман аялгуу болон салбарлажээ.

Орчин цагийн монгол хэлний олон аялгуу, аман аялгууг ажиглавал зарим нь монгол хэлний үлэмж дээр үеийн байдлын хадгалж, зарим нь их хувиран өөрчлөгдсөн ба зарим нь монгол хэлнийхээ баялгийг сайтар хадгалж, зарим нь харь хэлтэй ихэд хутгалдан уул аялгуугаар хэлэлцэгчид нь хоёр хэлтэн, заримдаа холимог хэлтэн болсон газар ч үзэгдэнэ. Орчин цагийн монгол хэлний олон аялгууны хоорондын зөрүү нь эртний ба дундад, мөн шинэ үеийн монгол хэлний байдлыг тусган үзүүлсэн янз бүрийн бичгийн дурсгалын хамтаар монгол хэл аялгуу мөн Алтайн хэлнүүдийг түүхийн үүднээс харшуулан судлахад үнэтэй материал болно. Энэ учраас сүүлийн жараад жилээс нааш монголч эрдэмтэн нар орчин цагийн монгол хэлний амьд аялгуунуудыг онцгой анхааран судалсаар иржээ.

Орчин цагийн монгол хэлний амьд аман аялгуунуудыг нягтлан судлах, ялангуяа тэдний хоорондын ялгавар дээр үндэслэж нарийн ангилах явдал монгол хэл, аялгууг түүхийн үүднээс харшуулан судалж, ер монгол хэлний түүхэн явц, түүний дотоодын хуулийг мэдэхэд чухал түлхэц болохоор үл барам монгол утга зохиолын хэл ба бичиг үсгийн ажлыг цаашид сайжруулах, бага, дунд, дээд сургуульд монгол хэл, бичиг заан сургах зэрэг ажилд нэгэн адил чухал холбогдоно.

2. Монгол хэл аялгууг судалж ангилах асуудлыг гол төлөв Орос ба Зөвлөлтийн монголч эрдэмтэн үүсгэн шинжилсээр иржээ. Гэвч сүүлийн жилүүдэд Бүгд Найрамдах Дундад Ард Улсад монгол хэл аялгууг судалж ангилах талаар үлэмжхэн ажил хийж, баялаг материал цуглуулсан байна.

Монгол хэл аялгууг судалж ангилсан эрдэмтний саналыг харьцуулан үзэхэд харилцан зөрүү газар багагүй байна. Энд бид монгол хэл аялгууг ангилан судалсан эрдэмтний гол саналыг урьдчилан авч үзье.

Оросын монголч эрдэмтэн А.Руднев 1908 онд монгол хэлний олон нутгийн аялгууг ангилсан нэг туршлагадаа монгол хэлийг *дорнод*, *умард*, *өрнөд* гэж гурван бүлэгт хуваагаад дорнод бүлэгт багтах аялгуунуудыг дотор нь:

1. *Ордос*, *цахар*, *түмэд*, *сөнидийн хэлэлцэх өмнөд аялгуунууд*

2. *Харчин*, *хорчин*, *онниуд*, *баарин*, *хишигтэн*, *үзэмчин*, *горлос*, *дүрвэд*, *халх нарын*

хэлэлцэх зүүн хойдын аялгуунууд гэж хоёр салбар болгон хуваажээ. Мөн умард бүлэгт багтах аялгуунуудыг дотор нь:

1. Түнхин, худь, алайр зэрэг буриадуудын хэлэлцэх Байгалын баруун биеийн аялгуунууд
2. Баргужин, Хорь, Сэлэнгийн зэрэг буриадуудын хэлэлцэх Байгалын зүүн биеийн аялгуунууд
3. Хөлөнбуйрын орчим нутаглах барга, буриадуудын хэлэлцэх барга аялгуу

гэж гурван салбар аялгуу болгон хуваажээ.

Өрнөд бүлэгт багтах аялгуунуудыг дотор нь:

1. Астарханийн халимагууд, Эзнээ гол, Алтай, Борхурын уулс, Хайду гол, Тянишианын нуруу, Хөхнуураар нутаглах торгуудуудын хэлэлцэх торгууд аялгуу
2. Астархань ба Ставрополь мужид орших халимагууд, Ховд хотоос хойш нутаглах дүрвэдүүд, Увс нуураас зүүн тийш нутаглах баядуудын хэлэлцэх дүрвэд аялгуу
3. Алиша мөн Ховд хот, Өлөнгөр нуурын орчим бас Хулж хотоос зүүн урагш жич, халхад Орхон, Тамираар нутаглах өөлдүүд, Чичигар хотоос баруун хойш нутаглах манай өөлдүүдийн хэлэлцэх өөлд аялгуу
4. Ижил мөрнөөс зүүн тийш Астархань мужид орших халимагууд, Юлтэсийн хөндий, Булган гол, жич, Хөхнуур, Цайдамаар нутаглах хошуудуудын хэлэлцэх хошууд аялгуу
5. Астархань мужийн халимагууд, Хөхнуур, Ховдын тойрог, халхад Увс нуураас зүүн урагш нутаглах хойдуудын хэлэлцэх хойд аялгуу

гэж таван салбар болгон хуваажээ.

Эцэст нь, Доны халимаг, Бузова, Терийн халимаг, Куманы халимаг, Уралын халимаг, Оренбургийн халимаг, Афганистаны могол, Дам голоор нутаглах Дамсог монгол, Шар уйгур, Ширайголын хэлэлцэх аялгууг нарийн ялган тодорхойлоогүй өрнөд аялгуунууд гэж нэрлэжээ.

А.Руднев монгол хэл, аялгууны тухай баримт мэдээ бүрэн бүтэн болоогүй байсан учир монгол хэл аялгууг жинхэнэ хэлний нь шинж байдлыг харгалзалгүй, гол төлөв эртний овог, аймаг, засаг захиргааг нь баримтлан ангилсан нь илэрхий байна. Орчин цагийн монгол хэл, аялгууны байдал нь эртний Монголын овог, аймгаар ялгарах газар арвин бий боловч Монголын нийгмийн сүүлчийн хэдэн зуун жилийн түүхэн нөхцөл байдалтай холбогдож монгол хэл аялгууг дан ганц овог, аймаг буюу засаг захиргааг баримтлан ангилж болохгүй болсон газар мөн арвин байна. Жишээлбэл, Орхон, Тамираар нутаглах өөлдүүд хэдийгээр гарлаараа Ойрадын тасархай боловч сүүлийн хэдэн зуун жилийн турш ямагт халх нарын дунд суусан учир одоо цэвэр халх аялгуутан болсон байна.

Зөвлөлтийн алдарт монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов 1929 онд Ленинград хотноо хэвлүүлсэн “Монгол бичгийн хэл ба Хүрээний халхын аялгууны хариуулсан хэл зүй” гэдэг номынхоо удиртгалд монгол хэл аялгууг ангилахдаа монгол хэлний олон нутгийн аялгууг зүүн, баруун салаа гэж хоёр том бүлэгт хуваагаад, баруун салаанд нь багтах аялгуунуудыг дотор нь:

1. Астарханийн дүрвэд, Астарханийн торгууд, Ховдын дүрвэд, баяд, захчин, мянгад, Алтайн урианхай, Дамбий-Өөлдийн хэлэлцэх ойрадын аялгуу
2. Афганистаны Моголын аялгуу

гэж хоёр бүлэгт хуваажээ.

Зүүн салаанд багтах аялгууг дотор нь:

1. Буриадын аялгуу (Доод-Үд, Алайр, Балгаан, Түнхэн, Ихирид, Булгад, Худай, Хавсал, Унги, идийн буриадын хэлэлцэх Байгалын хойд биеийн аялгуунууд, Худир, Цонгол, Баргужин, Хорь буриад)-ын хэлэлцэх Байгалын өмнөд биеийн аялгууг багтаажээ.
2. Барга буриадын аялгуу

3. Дагур аялгуу

4. Өвөр монголын аялгуу (Үүнд: харчин, жалайд, дүрвэд, горлос, найман, онниуд, хорчин, түмэд, цахар, сөнид, авга, авга нар, үзэмчин, хуучид, ордос, дөрвөн хүүхэд, муу мянган, урад)-ын монголчуудын хэлэлцэх аялгуунуудыг багтаажээ.

5. Халх аялгуу (Үүнд: жинхэнэ халх нар, хотгойд, дариганга нарын хэлэлцэх аялгуут багтаажээ)

гэж таван бүлэгт хуваажээ.

Б.Я.Владимирцовын ингэж ангилсныг А.Рудневийн ангилсантай зэрэгцүүлэн үзвэл Б.Я.Владимирцов гуай монгол хэл аялгууны тухай үлэмж нарийн хэрэглэгдэхүүнийг үндэслэн хийсэн нь илэрхий байна. Ялангуяа монгол хэлний зарим аялгууны хоорондын харьцааг нарийн ажигласан газар арвин байна. Жишээлбэл, Ховдын Ойрадын олон аялгууны дотроос халх нартай зах залгаа нутаглах, дүрвэд, захчин, баядын хэлэлцэх аялгууг Халх-Дүрвэд, Халх-Захчин, Халх-Баядын салбар аман аялгуу гэх зэргээр бодот байдлыг маш нарийн ажиглажээ. Гэвч монгол хэл, аялгууг Б.Я.Владимирцов гуай ингэж ангилах үед монгол хэл аялгуу ялангуяа Өвөр Монголын олонхи аялгууг сайн судлаагүй байсан учир Б.Я.Владимирцов Өвөр Монголын олон аялгууг мөн л гол төлөв овог, аймаг буюу засаг захиргааг баримтлан ангилжээ. Б.Я.Владимирцов гуайн энэ ангилалд Шинжаан, Хөхнуур, Ган-су мужийн монголчуудын хэл, аялгууны тухай материал байгаагүй учраас оролцсонгүй.

Зөвлөлтийн монголч эрдэмтэн Г.Д.Санжеев гуай 1953 онд Москва хотноо хэвлүүлсэн “Монгол хэлнүүдийн хариуулсан хэлзүй” гэдэг зохиолынхоо удиртгалд орчин цагийн монгол хэл аялгууг ангилсан нь:

1. Монгол хэл

2. Ойрад хэл

3. Буриад монгол хэл

4. Дагур хэл

5. Монгор хэл

6. Могол хэл

гэж зургаан төрөл хэл болгон хуваажээ. Үүнд, монгол хэлэнд нь Ар, Өвөр Монголын олон нутгийн аялгуу өөрөөр хэлбэл, халх, цахар, ордос, хорчин, харчин зэргийн олон аялгууг багтааж, ойрад хэлэнд нь Шинжаан, Хөхнуур, Алшаа, Эзнээ голын ойрад монголчуудын хэлэлцэх аялгууг багтаажээ.

Г.Д.Санжеев гуай ингэж ангилахдаа монгол угсаатны овог, аймгийн тархай бутархай байдал, мөн түүнийг үндэслэн тогтсон засаг захиргаа, улс төрийн хуваарийг ихээхэн анхаарсан мэт санагдана. Гэтэл орчин цагийн монгол хэл, аялгууны байдлыг ажиглавал овог аймаг, засаг захиргааны тархай бутархай байдлаар баримжаа болгож ангилахад тохирох газар ч байна, тохирохгүй газар ч байна. Жишээлбэл, Афганистаны могол, Ган-су мужийн монгорууд бусад монголчуудаасаа олон зуун жилийн турш тасархай байсан учир тэдний хэл, аялгууны байдал ч их өвөрмөц болж, хоорондоо мөн бусад монголчуудтайгаа харилцан нэвтрэлцэж чадахгүй, биеэ даасан хэлний шинжтэй болсон байна. Гэтэл Ар, Өвөр монголчууд мөн ойрад, буриад монголчууд хэдийгээр овог, аймаг, засаг захиргаагаараа ялгаравч байнгын харилцаатай явж ирсэн тул эдний хэл, аялгуу нь могол, монгорын хэл аялгууны адил бие биеэс тасарч, харилцан нэвтрэлцэж чадахгүй байдалд хүрсэнгүй, харин ойртсон газар цөөнгүй үзэгдэнэ. Энэ учраас Г.Д.Санжеев гуайн монгор, могол, дагурын үг хэлийг тус тусдаа биеэ даасан хэл, Ар, Өвөр Монголын олон аялгууг нэгэн монгол хэлний нутгийн аялгуу гэж үзсэн нь үнэн байдалд нийлвч ойрад, буриадын үг хэлийг тус тусдаа биеэ даасан хэл гэж үзсэн нь баахан эргэлзээтэй мэт санагдана.

Дагурын үг хэл бол хэл зүй, авиан зүй, үгсийнхээ сангийн талаар мөн могол, монгорын үг хэлний адил бусад монголчуудынхаа үг хэлнээс баахан тасархай өвөрмөц байдалтай боловч сүүлчийн хэдэн зуун жилийн турш төв монголчуудтайгаа холбоотой явж ирсэн ба дагурын сэхээтэн хүмүүс монгол бичгийн хэл, мөн төв монголынхоо үг хэлийг сайн мэддэг болсны дээр дагур хэлний Хайлаарын аялгуу нь төв монгол аялгуундаа ойртсон газар хааяа үзэгдэнэ.

Монголч эрдэмтэн Н.Поппе 1955 онд хэвлүүлсэн “Монгол хэлний харишуулсан шинжлэлийн удиртгал” гэсэн номондоо орчин цагийн монгол хэл, аялгууг Дорнод, Өрнөд гэж хоёр гол салаа болгон хуваагаад дорнод салаанд нь:

1. Дагур хэл (дотор нь Хайлаар аялгуу, Чичигаар аялгуу гэж хоёр хуваажээ)
2. Монгор хэл (дотор нь жинхэнэ Монгор аялгуу, Санта аялгуу, Шар Уйгур аялгуу, Ширай гол аялгуу, Арагва аялгуу, Санчуан аялгуу гэж зургаа хуваажээ)
3. Зүүн монгол хэл (дотор нь Халх аялгуу, Ордос аялгуу, Урад аялгуу, Түмэд аялгуу, Харчин аялгуу, Цахар аялгуу, Чивчин буюу хуучин Барга аялгуу гэж долоо хуваажээ)
4. Буриад хэл (дотор нь Ихирид аялгуу, Түнхэн аялгуу, Бохан аялгуу, Алайр аялгуу, Баргужин аялгуу, Хорь аялгуу, Агу аялгуу, Барга буриад аялгуу, Цонгоол аялгуу, Сартуул аялгуу гэж арав хуваажээ).

Өрнөд салаанд нь:

1. Могол хэл
2. Ойрад хэл
3. Халимаг хэл

гэж орчин цагийн монгол хэл аялгууг нийтэд нь долоон төрөл хэл болгон үзжээ.

Н.Поппегийн энэ ангилалт нь Г.Д.Санжеевын ангилсантай бараг адил бөгөөд гагцхүү халимаг аялгууг тусгаарлан салгаж, долоон төрөл хэл болгожээ. Н.Поппе орчин цагийн монгол хэл, аялгууг ингэж биеэ даасан долоон төрөл хэл болгон хуваахдаа Ар, Өвөр монголчууд бол биесээ монгол гэж нэрлэдэг учраас эдний үг хэл нь тус тусдаа биеэ даасан хэл биш, нэгэн монгол хэлний олон нутгийн аялгуу болно. Гэтэл могол, монгор, дагур, ойрад, халимагууд биесээ монгол гэдэггүй тул тэдний үг хэл нь тус тусдаа биеэ даасан хэл болно гэж үзсэн байна. Бодит байдлыг авч үзвэл орчин цагийн ойрад, буриадууд биесээ Ар, Өвөр монголчуудын нэгэн адил монгол угсаатан гэж сайн мэддэг бөгөөд зөвхөн монгол угсаатны чухам аль овог, аймгийн хүн болохоо мэдэлцэх гэвэл сая ойрад, буриад, халх, цахар, ордос, харчин, хорчин гэх зэргээр хэлэлцэнэ. Энэ учраас ойрадууд халх, цахар зэрэг монголчуудыг монгол гэхгүй халх, цахар буюу халх монгол, цахар монгол гэж, биесээ торгууд монгол буюу торгууд, өөлд монгол буюу өөлд гэх зэргээр хэлэлцэнэ. Мөн халимаг, буриадууд хэдийгээр харь хэлтэнд халимаг, буриад гэж алдаршсан боловч өвөр зуур мөн л халимагууд нь торгууд, дүрвэд, буриадууд нь хорь, алайр гэх зэргээр хэлэлцэнэ.

Дундад улс, мөн Монгол улсад оршин суух ойрадууд нь биесээ ойрад гэж нэрлэхгүй болсноор үл барам, залуу үеийн хүмүүс нь ойрад гэдэг үгээ ч мэдэхгүй болж хааяа торгууд, дүрвэд, өөлд гэж нэрлэвч ихэнхдээ энэ тэр нутгийн монголчууд гэж хэлэлцэх болсон байна. Энэ байдлаас үндэслэж, одоо Дундад улсад ойрадын олон аймгийг урьдын нь овог, аймгийн нэрээр нэрлэхгүй Шинжааны монголчууд, Хөхнуурын монголчууд, Алшаа, Эзнээ голын монголчууд гэх зэргээр зөвхөн орон нутгаар нь ялгаж, цөмийг монгол гэж нэрлэх болсон байна. Хөхнуурын монголчуудыг бас Дээд монгол гэж нэрлэнэ. Сүүлийн үед Ар, Өвөр Монголд ч мөн биесээ хуучныхаа овог аймгийн нэрээр нэрлэх явдал улам ховор болж байна. Жишээлбэл, Өвөр Монголд хүнээс -Чи хаанахын ямар хүн бэ? гэж асуухад би Жуу-Уд аймгийн монгол хүн, би Жирим аймгийн монгол хүн, би Шилийнгол аймгийн монгол хүн гэхээс бус би харчин хүн,

хорчин хүн, авга буюу сөнид хүн гэж хариулахгүй болсон байна. Ар Монголд бол халх хүн гэхээс монгол хүн гэж хариулах нь арвин болж хүүхэд бол халх гэдэг үгийг бараг мэдэхгүй болсон байна. Энэ мэтээр орчин цагийн монгол угсаатны олонхи нь биесээ хуучныхаа овог, аймгийн нэрээр нэрлэхгүй болж, гол төлөв орон нутаг, засаг захиргааныхаа нэрээр ялгаж, цөм монгол гэж хэлэлцэх болж байна. Хааяа засаг захиргааны нэрийг урьдын аймгийн нэрээр нэрлэсэн газар уул овог, аймгийн нь нэр хэвээр үлдэх төлөвтэй байна. Жишээлбэл, Цахар аймаг, Түмэд хошуу гэх мэт. Энэ учраас орчин цагийн монгол хэл аялгууг ангилахад биесээ монгол гэж хэлдэг эсэхээр баримжаа болгох аргагүй байна.

Бүгд Найрамдах Дундад Ард Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Хэл судлах газар, Төвийн Үндэстний Дээд Сургууль, Өвөр Монголын Хэл бичиг судлах хурал зэрэг газраас 1955 оноос эхэлж Дундад улсын доторхи монгол үндэстний хэл, аялгууг өргөн хэмжээгээр судалж эхэлсэн бөгөөд үүний урьдчилсан дүнг нутгийн аялгуу судлагч Чингэлтэй Хөххотноо хэвлэх “Монгол түүх хэл бичиг” сэтгүүлийн 1957 оны 11 дүгээрээс эхлэн цувруулан нийтэлжээ. Үүндээ нөхөр Чингэлтэй Дундад улс дахь монгол төрлийн хэл, монгол хэлний аялгууг ангилсан байдал нь:

1. Монгол хэл
2. Дагур хэл
3. Монгор хэл
4. Дунишаан хэл
5. Баон хэл
6. Шар уйгур хэл

гэж тус тусдаа биеэ даасан зургаан төрөл хэл болгон хуваажээ. Үүнээс монгол хэлийг дотор нь:

1. Барга буриад аялгуу (дотор нь шинэ барга, хуучин барга, буриадын аман аялгуу гэж гурав хуваажээ).
2. Зүүн аялгуу (дотор нь Баарин, Ар хорчин, Найман, Онниуд зэрэг монголчуудын хэлэлцэх Жуу-Удын аман аялгуу, Жиримийн аймаг (үүнд Хүрээ хошууг оруулахгүй), Хөлөнбуйр аймаг (үүнд баргыг оруулахгүй), жич, Хар мөрөн, Гирин мужийн монголчуудын хэлэлцэх Жиримийн аман аялгуу, Харчины хэдэн хошууд, Зүүн орны Түмэдийн хэдэн хошууд, жич, Хүрээ хошууны монголчуудын хэлэлцэх Жостын аман аялгуу гэж гурав хуваажээ).
3. Төв аялгуу (дотор нь Шилийнгол аймгийн сөнид Баруун, Зүүн хошуу, Авга хошуу, Улаанцав аймгийн Дархан муу мянган холбоот хошуу, Дөрвөн хүүхэд хошууны хойд хэсэг, Шинэ барга хошууны хоёр сумын монголчуудын хэлэлцэх Шилийн голын аман аялгуу, Цахар аймгийн олон хошуу, Жуу-Уд аймгийн Хишигтэн хошуу, Шилийнгол аймгийн Үзэмчин хошуу, Улаанцав аймгийн Урадын хошуу, Дөрвөн хүүхэд хошууны өмнөд хэсэг, Пиндигуан, Хэтоу засаг захиргааны монголчуудын хэлэлцэх Цахарын аман аялгуу, Их Жуугийн олон хошуудын монголчуудын хэлэлцэх Ордосын аман аялгуу гэж гурав хуваажээ).
4. Баруун аялгуу (дотор нь Алишаа хошуу, Эзнээ хошуу, Ган-су мужийн Сү-бэй дэх Монгол үндэстний өөртөө засах сианийн монголчуудын хэлэлцэх алишаагийн аман аялгуу, Хөхнуурын монголчуудын хэлэлцэх хөхнуурын аман аялгуу гэж хоёр хуваажээ).
5. Ойрад аялгуу (Үүнд Шинжааны Уйгур үндэстний өөртөө засах оронд суух ойрад монголчуудын хэлэлцэх аялгууг багтаажээ) гэж тав хуваажээ.

Дагур хэлийг дотор нь Чичигарын аман аялгуу, Бодха аман аялгуу, Шинжааны аман аялгуу, Хайлаарын аман аялгуу гэж дөрөв хуваажээ.

Монгол хэлийг дотор нь *хуцо аялгуу, мингээ аялгуу* гэж хоёр хуваажээ. Нөхөр Чингэлтэй ингэж ангилахдаа сүүлийн жилүүдэд Дундад улсад монгол угсаатны хэл аялгууг судлахад цугларсан баялаг их хэрэглэгдэхүүнийг тулгуурлан хийсэн байна. Үүний урьд монгол хэл, аялгууг туршин ангилсан хүмүүсийн гарт Дундад улсын доторхи монгол угсаатны хэл аялгууны тухай ийм арвин их хэрэглэгдэхүүн байсангүй. Энэ учраас, нөхөр Чингэлтэйн ангилалт илүү нарийн байх нь аргагүй ажээ. Чингээд нөхөр Чингэлтэй монгол хэл, аялгууг дан ганц овог аймаг буюу засаг захиргааг нь баримтлалгүй, юуны өмнө хэлний шинж буюу аль зэрэг харилцан нэвтрэлцэж чадах эсэхийг нь ихээхэн анхаарч ангилсан учир монгол хэл, аялгууны өнөөдрийн бодит байдлыг илүү нарийн тусгаж чадсан байна.

Г.Д.Санжеев, Н.Поппе хоёрын бие даасан төрөл хэл гэж үзсэн Ойрад ба Барга буриадын үг хэлийг нөхөр Чингэлтэй монгол хэлний салбар аялгуу гэж үзжээ. Мөн Өвөр Монголын олон нутгийн аялгуу, аман аялгууны хоорондын харьцааг нарийн гаргаж төв аялгуу, зүүн аялгуу гэх зэргээр хуваасан нь их оновчтой болжээ. Гэвч нөхөр Чингэлтэй хэлнийхээ шинж байдлаар биеэ даасан ноцтой онцлог бүхий аялгуу, тийм биеэ даасан онцлоггүй, хоёр аялгууны завсрын шинжтэй аялгуу буюу өөрөөр хэлбэл гол аялгуу, завсрын аялгууг ялгалгүй адил тэгш үзсэн нь дутагдалтай мэт санагдана. Жишээлбэл, Хөхнуур, Энээ гол, Алшаагийн монголчуудын үг хэл нь гарлаараа ойрадын аялгуу боловч одоо төв аялгуу руу хэлбийж, завсрын аман аялгууны шинжтэй болсныг биеэ даасан баруун аялгуу гэж нэрлэсэн байна. Үүнчлэн барга буриадын аялгуу гэсэн нь үнэндээ *халх-буриадын завсрын аман аялгуу* юм.

3. Орчин цагийн монгол хэл, аялгууг ангилахад чухам ямрыг нь нэгэн монгол хэлний салбар аялгуу, ямрыг нь биеэ даасан төрөл хэл гэж үзэх вэ? Төрөл хэл, нутгийн аялгуу хоёрын заагийг ялган тодорхойлоход ямар зарчмыг баримтлах вэ гэдэг асуудал аяндаа гарч ирнэ.

Г.Д.Санжеев гуай хэл ба түүний салбар аялгуу хоёрын харьцааг тодорхойлохдоо захирах, захирагдах харьцаа, дээд хэлбэр, доод хэлбэрийн харьцаа буюу өөрөөр хэлбэл, аливаа нэгэн хэлний нутгийн аялгуу нь тухайн ястан үндэстний хэлний дотоодын хуульд захирагдаж байдаг. Аль нэг үндэстний бүх ард түмэнд нэгэн адил ойлгогдох нийт дундын дээд хэлбэр, түүний зэрэгцээгээр зөвхөн нутаг нутгийн аялгууны онцлогийг тусгасан доод хэлбэр байдаг гэсэн мэдээж үндэслэлийг баримталж Ар, Өвөр Монголын хэлэлцэх олон нутгийн аялгуу нь нэгэн монгол хэлний хуульд захирагдаж яваа тул тус тусдаа биеэ даасан төрөл хэл биш, нэгэн монгол хэлний салбар аялгуунууд болно. Гэтэл могол, монгол, дагур, ойрад, буриадын хэлэлцэх үг хэл нь нэгэн монгол хэлний дотоодын хөгжлийн хуулиар хөгжиж эхэлсэн учир тус тусдаа биеэ даасан төрөл хэл болжээ гэж үзсэн байна.

Г.Д.Санжеев XIII зууны үед нэгдмэл байсан монгол хэл Чингис хааны байлдан дагуулах дайнаар монголчууд Ази, Европын асар уудам өргөн газар сарнин тараад дараагаар нь Чингисийн байгуулсан Монголын эзэнт улс задарсан явдалтай холбогдож монгол хэлний зарим аялгуу эх монгол хэлнээсээ тасарсны үр дүнд эхлээд монгол, могол, дагур, дараагаар нь ойрад, буриад аялгуу тус тусдаа биеэ даасан хэл болон хөгжсөн байх гэж тайлбарлаж байна.

Орчин цагийн монгол хэл, аялгууг ангилахад тэдгээр хэл, аялгуугаар хэлэлцэгч ард түмний өнгөрсөн түүх, ялангуяа одоо үеийн нь бодит байдлыг анхаарахгүй байж үл болох нь мэдээж хэрэг юм. Гэвч алив үндэстний нийгэм, улс төрийн хувиран өөрчлөгдөх нь түүний хэл, аялгууны хувиран өөрчлөгдөхөөс түргэн гэдгийг мартаж үл болно. Үүнээс гадна хэл, аялгуу бол хүмүүсийн харилцахын хэрэглүүр болох учир уул хэл, аялгуугаар хэлэлцэгч ард түмний нийгэм, улс төрийн янз бүрийн нөхцөл байдлын дотроос эдийн засаг, соёл, улс төрийн харилцаа нь тэдний хэл, аялгуунд хамгийн чухал холбогдох учиртай ажээ. Өөрөөр хэлбэл, аль нэгэн ястан, үндэстний төвлөрсөн улс төр задравч хэрэв тэд улс төр, соёл, эдийн засгийн

талаар байнгын холбоотой байвал тэдний хэл, аялгуу заавал задарч, тус тусдаа биеэ даасан төрөл хэл болон хөгжих албагүй юм. Жишээлбэл, Монголын эзэнт улс задарсны дараагаар Афганистаны моголууд, мөн Ган-су мужийн монгорууд төв монголчуудаасаа улс төр, соёл, эдийн засгийн талаар бүрмөсөн тасарсан боловч Ар, Өвөр монголчууд, мөн ойрад, буриад монголчууд бие биеэсээ чингэж бүх талаар тасарсангүй учраас тэдний хэл аялгуу ч мөн тус тусдаа биеэ даасан төрөл хэл болон хөгжиж чадсангүй нэгэн монгол хэлний салбар аялгуу, аман аялгуу байсан хэвээрээ үлджээ. Монголын эзэнт улсын задран мөхсөнөөс хойш ар, өвөр монголчууд, мөн ойрад, буриад монголчууд олон талаар нягт холбоотой явж ирсэн нь тэдний сүүлчийн хэдэн зуун жилийн түүхэнд илэрхий байна.

XIV-XVII зууны үе хүртэлх Монголын дотоодын феодалын дайн, Манжийн байлдан дагуулах дайны үед ар, өвөр монголчууд, мөн ойрад монголчууд харилцан маш их хутгалдсан нь илэрхий бөгөөд бодвол энэ үед дурдсан монгол угсаатан Чингисээс өмнөх үеийн Монголын олон овог аймгийн хоорондын байлдаан, мөн Чингисийн үед монгол угсаатны харилцан хутгалдсанаас дутуугүй хутгалдсан байж таарна. Энэхүү Монголын дотоодын феодалын байлдаан, Манжийн довтолгоонд буриадууд хамран оролцоогүй боловч дурдсан байлдааны үед үлэмжхэн тооны халх, ойрадууд буриад нутагт дүрвэн орсон тул энэ үед буриадуудыг бусад монголчуудаасаа бүрмөсөн тасархай байсан гэж үзэж үл болно. Ингэж Монголын олон овог, аймгийн хүн харилцан хутгалдахад тэдний хэл, аялгуу бие биедээ ойртохгүй байж чадахгүй байв.

XVIII зууны тэргүүн хагасаас эхлэн энэ тэргүүн өвөр монголчууд, дараагаар нь ар монголчууд, эцэст ойрадууд Манж Чин улсын захиргаанд орсон бөгөөд манж нар нэг талаар монголчуудын хүчийг сарниулах зорилгоор тэдний феодалын тархай бутархай байдлыг улам бэхжүүлж, улам бутаргах төрийн бодлогыг явуулсан боловч нөгөө талаар, өөрсдөө монголчуудыг дарангуйлан захирах зорилгоор Бээжингээс Хүрээ, Улиастай, Ховд хязгаар хүртэл морин өртөө байгуулсан ба чингэхдээ харчины ардуудыг нүүлгэн аваачиж, халхын дундах говь замын өртөөний алба хаалгах, халх нарыг Ховд хязгаарт нүүлгэн аваачиж морин өртөөний алба хаалгахаар үлэмжхэн тооны цахар, дагуруудыг нүүлгэн суулгах зэргээр мөн монголчуудыг хооронд нь хутгажээ.

Ялангуяа Манж Чин улсын үед Монгол оронд феодалын дотоодын байлдаан зогсож, хятад монголчуудын хооронд соёл, эдийн засгийн харилцаа өргөжиж, Хятадын бараа таваар Монгол орны хамгийн алсалсан хязгаар нутаг хүртэл нэвтэрдэг болж, энэ бараа таваарыг тээх тэмээн жингийн ажлыг гол төлөв монголчууд эрхэлдэг байсан учир ар монголчууд нь Өвөр Монголыг дайран Умард Хятад ба Зүүн-хойд Хятадын олон хот руу жин тээж, Ар Монголын худалдааны төвүүдэд хүрэх зэргээр байнга харилцдаг байсан ба дараагаар Хятад, Оросын худалдаа хөгжиж эхлэхэд Бээжин, Хаалган, Хүрээ, Хиагт, Дээд-Үд нь нэг үе Орос-Хятадын худалдааны гол зам болж, монголчуудын жин тээврийн ажил өргөжихөд ар өвөр монголчуудаар үл барам, буриад монголчууд ч энэхүү өргөн харилцаанд оролцож эхэлсэн байна. Энэ бүгд нь дурдсан монголчуудын хэл аялгууны бие биедээ ойртоход нөлөөлөхгүй байж болохгүй байна.

Ар, өвөр монголчууд, мөн буриад, ойрад монголчууд нийт дундаа нэг бичгийн хэлтэй байсан явдал бас тэдний хэл аялгууг харилцан ойртоход нөлөөлөхгүй байж болохгүй байв. Монголын эзэнт улсын задран мөхсөний дараа монгол бичгийн хэл мартагдан орхигдсонгүй. Мөн Юань улсын үеийн адил төрийн бичиг хэрэг, бурхан шашны ном судар орчуулах зохиоход монгол бичгийн хэлийг хослон хэрэглэсээр иржээ. Ялангуяа Манж Чин улсын үед Бээжин, Хөххот мэтийн соёлын чухал төвүүдэд бурхан шашны монгол ном судар, жич, түүх сургаал, яруу найргийн зохиол, янз бүрийн толь бичгийг модон бараар маш арвин хэмжээтэйгээр хэвлэж, Монгол орны хамгийн алсалсан нутагт хүртэл тараах болсон ба Ар, Өвөр Монгол, Баруун Монголд аймаг хошуу, сум, баг гэх мэтчилэн цэрэг захиргааны албан газрууд маш

олширч хамаг албан хэргийн бичгийг монгол үсгээр явуулах болсон нь монгол бичгийн хэлний хэрэгцээг ихэд өргөтгөж, улмаар монгол хэлний олон нутгийн аялгууг бие биед нь ойртуулахад чухал нөлөө үзүүлсэн байна. Ойрадууд хэдийгээр XVII зууны үеэс хуучин монгол үсгийг бага сага засамжилж, өөрийн тусгай тод үсэг зохион хэрэглэсэн боловч Шинжаан, Хөхнуур, Алшаа, Эзнээ, Ховдын ойрадууд Манж Чин улсын харьяанд орсноос хойш албан хэрэгт мөн хуучин монгол үсгийг голлон хэрэглэх болсон ба буриадын дунд монгол бичгийн хэл арай хожим нэвтэрсэн боловч XVIII зууны үеэс эхлэн хүчтэй дэлгэрч, монгол модон барын хэвлэл хүртэл ихэд хөгжжээ.

Юань улсын үеэс монголчуудын дунд улам улам нэвтэрч байсан Бурханы шашин нь XVII зууны үеэс эхлэн хуваарьгүй ноёрхож, Монгол оронд энд тэндгүй сүм хийд байгуулагдаад, шашин мөргөлийн хэргээр нааш цааш явалцах нь улам арвин болж, Их Хүрээний Гандан хийд мэтийн их сүм хийдүүдэд Монголын олон нутгийн хүмүүс цугларч, шашны сургууль хийх, эргэл мөргөл хийх, мөн шашин мөргөлийн хэргээр Ар, Өвөр Монгол, Буриад, Ижил мөрний халимагууд, Алшаа, Эзнээ гол, Хөхнуурыг замнан, Баруунзуу, Лхас Гүмбэн, Лавранд байнга ирж очих болсон явдал нь монголчуудын хоорондын харилцааг өргөтгөж, улмаар тэдний хэл, аялгууг бие биед нь ойртуулахад түлхэц болж байсан нь маргаангүй.

Ар, өвөр монголчууд, мөн ойрад, буриад монголчууд жин тээвэр, шашин мөргөлийн хэргээр үргэлж нэвтрэлцэж байснаас гадна энгийн байдлаар хэрэн явалцах, ямар нэг дайн дажин, улс төрийн хөдөлгөөний улмаас нэг нутгаас нөгөө нутагт хэсэг бүлгээр нүүдэллэн орох явдал тасралтгүй үргэлжилсээр иржээ. Жишээлбэл, 1920-оод оны үеэсээр үлэмжхэн тооны буриадууд Ар ба Өвөр Монголд нүүдэллэн орсон, 1930-аад оны үеэсээр нэлээд тооны халх монголчууд Өвөр Монгол, Эзнээ гол, Алшаад нүүдэллэн орсон, 1945 оны үеэр үлэмжхэн тооны өвөр монголчууд Ар Монголд нүүдэллэн орсон зэргийг дурдаж болно.

Үүнээс гадна, ар, өвөр монголчууд, буриад монголчууд нь эртнээс нааш үргэлж зах залгаа нутаглаж, зарим газар хутгалдан суусан, Монгол орны төв ба өрнөд хэсгийн маш өргөн уудам газар оршин суух монголчууд нь нэгэн адил нүүдлийн мал аж ахуйг эрхэлсээр ирсэн зэрэг харилцан нэвтрэлцэхэд дөхөмтэй газар зүй, эдийн засгийн бусад нөхцөл байдлыг бас анхаарах хэрэгтэй. Нүүдлийн байдал нь харилцан нэвтрэлцэхдээ дундад зууны үеийн зам харилцаа муутай суурьшсан газраас илүү дөхөмтэй байсан нь илэрхий юм. Энэ мэтээр ар, өвөр монголчууд, мөн буриад монголчууд нь улс төр, эдийн засаг, соёл, шашин суртахуун, хэв заншлын талаар эртнээс нааш нягт холбоотой явж ирсэн бөгөөд энэ нь дурдсан монголчуудын хэл, аялгууг бие биеэс нь хөндийрүүлэхгүй холбож байсан төдийгүй харин хооронд нь улам улам ойртуулж байжээ.

Аливаа нэгэн хэлэнд олон нутгийн аялгууны зэрэгцээгээр уул аялгуунуудыг нэгтгэн холбосон тухайн үндэстний бүх ард түмэнд нэгэн адил ойлгогдох нийт дундын дээд хэлбэр байх ёстой нь маргаангүй юм. Ийм нийт дундын дээд хэлбэргүйгээр нэг хэл гэж үзэхэд бэрхтэй болох нь мэдээж хэрэг юм.

Орчин цагийн ар, өвөр монголчууд, ойрад, буриад монголчуудын хэлэлцэх үг хэлэнд эдгээр үг хэлийг холбосон нийт дундын дээд хэлбэр байна уу? Хэрэв байвал энэ нь яаж илэрч байна гэдгийг авч үзэх хэрэгтэй.

Ар, өвөр монголчууд, ойрад, буриадын хэл, аялгуу, авианзүй, хэлзүйн талаар харьцуулан үзэхэд хэрэв ялгавартай газар нь арав хориодоос хэтрэхгүй бол адил төсөөтэй, нийт дундын шинжтэй зүйл нь маш ихэнх хувийг эзэлж байна. Үгсийн сангийн талаар дурдсан монголчуудын үг хэл нь мөн маш нэгдмэл юм. Энэ учраас эд нар харилцан саадгүй нэвтрэлцэж чаддаг ажээ. Энэ бол эдгээр монголчуудын эрт дээд үеийн нь үг хэлний нийт дундын зүйл нь манай үе

хүртэл тасралгүй уламжлан ирээд одоо ч мөн нийт дундын дээд хэлбэр нь болсоор байгаагийн нэгэн илрэл юм. Энэ байдал нь ялангуяа янз бүрийн аялгууны хүмүүсийн харилцан хэлэлцэхэд ив илэрхий мэдэгдэнэ. Жишээлбэл, *төв аялгуу буюу халх, цахар, ордосын аман аялгуугаар хэлэлцэхэд энэхүү төв аялгуунд ихээхэн ойрхон бөгөөд завсрын шинжтэй Барга, Ар хорчин, Баарин, Онниуд, Найман, Сэлэнгийн буриад, Хөхнуур, Ашаа, Эзнээ гол, Ховдын ойрадын хэлэлцэх аман аялгууны хүмүүс өчүүхэн ч саадгүй сайн ойлголцоно. Мөн төв аялгуугаар хэлэлцэхэд Дорнод, Харчин, Хорчин, Өрнөд Шинжаан ба Ижил мөрний ойрадууд, Умард Буриадын аялгууны хүмүүс, хэрэв холимог хэлтэн биш бол бэрхшээлгүй ойлголцоно. Гэтэл харчин, хорчин, ойрад, буриадын аялгууны хүмүүс шууд хоорондоо хэлэлцэхэд ойлголцох боловч бэрхшээлтэй газар хааяа тохиолдоно. Үүнд, монгол угсаатны өнцөг буланд харь хэлтэнтэй хутгалдан суух зарим монголчууд холимог хэлтэн болж, монгол үг хэлээ баахан мартсан газар байдаг бөгөөд тийм нутгийн монголчууд бусад монголчуудтайгаа монгол үг хэлээр харилцан нэвтрэлцэхэд төвөгтэй болсон байдаг нь тэдний язгуурын нутгийн аялгууны зөрүүгээс буюу эсэхүл хоёр хэл хутгалдаж шинэ хэл буй болсноос биш, эх хэлээ мартсанаас болсон нь мэдээж хэрэг юм. Энэ мэтээр орчин цагийн ар, өвөр, монголчууд, ойрад, буриадын хэлэлцэх олон нутгийн аялгуу, аман аялгуу нь хоорондоо холбоогүй, салангид хэлнүүд биш, харин төв аялгуундаа захирагдсан, нэгэн монгол хэлний олон нутгийн аялгуу, аман аялгуу болох нь илэрхий ажээ. Гэвч орчин цагийн монгол хэлний төв аялгуу ба түүн дээр үндэслэсэн монгол утга зохиолын хэлний зах өнцгийнхөө олон аялгуу, аман аялгууг хамран нөлөөлөх байдлыг Европын зам харилцаа, хэвлэл ихэд хөгжсөн үндэстний төв аялгуу, түүн дээр үндэслэсэн бичгийн хэлний олон аялгуундаа нөлөөлөх байдалтай зэрэгцүүлэн үзвэл сул ажээ. Энэ байдал ганц монгол хэлэнд байгаа биш мөн Ази, Африкийн феодализм ба феодализмын өмнөх үеийн харилцаа удтал ноёрхож байсан орны их, бага янз бүрийн үндэстний хэлэнд нэгэн адил байгаа бололтой тул энэ мэт үндэстний хэл, аялгууг ангилахдаа хөгжсөн үндэстний хэл, аялгууг ангилсан байдлыг шууд хуулалгүй, эрхбиш тус тусын хэлний онцлог, түүхэн нөхцөл байдлыг голлон анхаарч ангилбал зүйтэй мэт. Чингэхгүй бол дорно дахины зарим хэлний нутгийн аялгуунуудыг олон төрөл хэл гэж дүгнэлт хийхэд хүрч магадгүй.*

Орчин цагийн монгол хэлний олон нутгийн аялгуу, аман аялгууг ангилахад юуны өмнө хэлнийх нь шинж буюу өөрөөр хэлбэл авианзүй, хэлзүй, үгийн сангийн онцлогийг үндэс болгож **аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуу** гэж гурван зэрэг болгон хуваавал тохиромжтой мэт санагдана. Энд бид хэлнийхээ шинжээр ноцтой ялгавар байхгүй харилцан өчүүхэн ч саадгүй нэвтрэлцэх бүлэг хүмүүсийн үг хэлийг **аялгуу** гэж нэрлэлээ. Нэг нутгийн аялгуу нь нөгөө нутгийнхаа аялгуунаас хэлнийхээ шинжээр мэдэгдэхүйц ялгарна. Мөн хэлнийхээ шинжээр ерийн хэлэлцэхэд ялгавар байхгүй. Нэг нутгийн бүлэг хүмүүсийн хэлийг **аман аялгуу** гэж нэрлэв. Нэг аман аялгуу нь нөгөөгөөсөө нарийвчлан ажиглавал, хаяа авианзүй, үгсийнхээ сангийн талаар өчүүхэн ялгарна. Нэгэн аман аялгууны дотор багтавч хаяа авианзүй, үгсийнхээ сангийн талаар гол олонхоосоо өчүүхэн ялгарах нэг нутгийн бүлэг хүмүүсийн үг хэлийг **салбар аман аялгуу** гэж нэрлэв. Эл зарчмыг баримталж, сүүлийн жилүүдэд Дундад улсад монгол хэл аялгууг судалсны дүнд илэрсэн баялаг материалыг үндэс болгож орчин цагийн монгол хэлний олон аялгууг ангилбал ерөнхийдөө дараа дурдсан дөрвөн үндсэн аялгуу, хэдэн аман аялгуунд хуваагдана.

НЭГ. ТӨВ АЯЛГУУ

1. *Халхын аман аялгуу*
2. *Цахарын аман аялгуу*
3. *Ордосын аман аялгуу*

ХОЁР. ДОРНОД АЯЛГУУ

1. *Хорчины аман аялгуу*
2. *Харчины аман аялгуу*

ГУРАВ. ӨРНӨД АЯЛГУУ

1. *Шинжааны ойрадын аман аялгуу*
2. *Ижил мөрний ойрадын аман аялгуу*

ДӨРӨВ. УМАРД АЯЛГУУ

1. *Байгалын өмнөд биеийн буриадын аман аялгуу*
2. *Байгалын хойд биеийн буриадын аман аялгуу*

Үүнээс гадна эл дөрвөн аялгууны завсрын шинжтэй хэд хэдэн аман аялгуу бий нь

НЭГ. ТӨВ БА ДОРНОД АЯЛГУУНЫ ЗАВСРЫН АМАН АЯЛГУУНУУД

1. *Ар Хорчин, Баарины аман аялгуу*
2. *Онниуд, Найманы аман аялгуу*

ХОЁР. ТӨВ БА ӨРНӨД АЯЛГУУНЫ ЗАВСРЫН АМАН АЯЛГУУНУУД НЬ

1. *Хөхнуурын ойрадын аман аялгуу*
2. *Алиаа, Эзнээ голын ойрадын аман аялгуу*
3. *Ховдын Ойрадын аман аялгуу*

ГУРАВ. ТӨВ БА УМАРД АЯЛГУУНЫ ЗАВСРЫН АМАН АЯЛГУУНУУД

1. *Сэлэнгийн буриадын аман аялгуу*
2. *Баргын аман аялгуу*

эдгээр болно.

Монгол хэлний төв аялгуугаар халх, цахар, ордос монголчууд хэлэлцэх бөгөөд эдний хүн амын тоо нийтдээ 1.200.000-д хүрнэ. Үүнээс халхын аман аялгуугаар одоо жинхэнэ халх нараас гадна Ар Монголд халх нарын дунд удтал хутгалдан суусан *ойрад*, *буриад*, *харчин*, *хорчин*, *барга*, *үзэмчин*, Өвөр Монголд бол *авга*, *сөнид*, *Улаанцав аймгийн Дархан муу мянган холбоот хошуу*, *Дөрвөн хүүхэд хошууны хойд хэсэг*, *Шинэ барга* хошууны хоёр сумын хүн ард хэлэлцэнэ. Халхын аман аялгуугаар нийтдээ 1 сая орчим хүн хэлэлцэнэ. Цахарын аман аялгуугаар цахарын олон хошууд, Жуу-Уд аймгийн Хишигтэн хошуу, Шилийнгол аймгийн үзэмчин хошуу, Улаанцав аймгийн урадын хэдэн хошуу, Дөрвөн хүүхэд хошууны өмнөд хэсэг, Пиндичуан, Хэтоу засаг захиргааны монголчууд хэлэлцэнэ. Цахарын аман аялгуугаар 100.000-аад хүн хэлэлцэнэ. Ордосын аман аялгуугаар Их зуугийн аймгийн олон хошуудын монголчууд хэлэлцэнэ. Эл аман аялгуугаар нийтдээ 60.000 гаруй хүн хэлэлцэнэ. Нарийвчлан ажиглавал халх, цахарын аман аялгуунууд дотроо бас хоорондоо маш ойрхон салбар аман аялгуунууд байдаг. Жишээлбэл, халхын аман аялгууны дотор *авга*, *сөнидийн салбар аман аялгуу*, *даригангын салбар аман аялгуу*, *хотгойдын салбар аман аялгуу*, *дархадын салбар аман аялгуу*, *халх-дүрвэдийн салбар аман аялгуу*, *халх-баядын салбар аман аялгуу*, *халх-захчиний салбар аман аялгуу*, *цахарын аман аялгууны дотор үзэмчиний салбар аман аялгуу*, *хишигтний салбар аман аялгуу*, *ордосын салбар аман аялгуу* гэх мэт.

Монгол хэлний төв аялгуу нь хамгийн өргөн уудам газар тарж, энэ аялгуугаар хамгийн олон хүн ард хэлэлцэхээс гадна янз бүрийн нарийн хэллэг, үгсийн сангийн баялаг, монгол хэлний өвөрмөц онцлогийг цэвэр хадгалснаараа бусад аялгуунаасаа давуу талтай ажээ. Бас төв аялгуугаар хэлэлцэгчдийн дунд харь хэл бараг нэвтрээгүй, дан монгол үг, хэлээр хэлэлцэх тул эртнээс нааш хамаг хэргийг монгол бичгийн хэлээр явуулж ирсэн ба үүний үрээр монгол бичгийн хэлэнд төв аялгууны нөлөө улам улам нэвтэрч, хэрэг дээрээ төв аялгуу нь хэл зүй, үгсийн сангийнхаа талаар орчин цагийн монгол утга зохиолын хэлний суурь аялгуу болсон байна. Нөгөө талаар, төв аялгуугаар хэлэлцэгчид нь монгол бичгийн хэлийг өдөр тутмынхаа амьдралд байнга хэрэглэсээр ирсэн учир олон зуун жилийн турш монгол хэлний олон нутгийн аялгуунаас шилэгдэж, олон үеийн бичгийн хүний боловсруулсан монгол бичгийн хэлний яруу сайхан хэллэг, найруулга, үгийн баялаг нь төв аялгуунд нэвтрэн нөлөөлж энэ аялгууг улам хүчтэй болгосон байна.

Төв аялгуу нь дотроо маш нэгдмэл бөгөөд хэл зүйн талаар бараг ялгавар байхгүй, авиан зүй, үгсийн сангийн талаар өчүүхэн ялгавар бий. Жишээлбэл, халхын аман аялгуунд *ts, tš, dz, dž* дөрвөн хамжин шүргэх гийгүүлэгч байхад цахар, ордосын аман аялгуунд *tš, dž* хоёрхон хамжин шүргэх гийгүүлэгч байх буюу цахар, халхын аман аялгуунд үгийн тэргүүн үеэс хойших богино эгшгийг маш огцом балархай хэлдэг бол ордосын аман аялгуунд баахан тод хэлэх мэт ажээ.

Монгол хэлний дорнод аялгуугаар хорчин, харчины монголчууд хэлэлцэх бөгөөд эдний хүн амын тоо нийтдээ 900.000 гаруй болно. Үүнээс хорчины аман аялгуугаар жиримийн аймаг (Хүрээ хошууг оруулахгүй), Хөлөнбуйр аймаг (Баргыг оруулахгүй), жич, Хар мөрөн, Гирин мужид оршин суух монголчууд хэлэлцэнэ. Хорчиний аман аялгуугаар нийтдээ 540.000 гаруй хүн хэлэлцэнэ.

Харчины аман аялгуугаар харчины хэдэн хошууд, зүүн орны түмэдийн хэдэн хошууд, жич, Хүрээ хушууны монголчууд хэлэлцэнэ. Харчины аман аялгуугаар нийтдээ 350.000 гаруй хүн хэлэлцэнэ.

Хорчин, харчины аман аялгуунууд дотроо бас мэдэгдэхүйц ялгавар бүхий салбар аман аялгуунууд байдаг. Жишээлбэл, хорчины аман аялгууны доторх жалайд, дүрвэдийн салбар аман аялгуунд *s* авиаг *t*-ээр солих мэт (жиш: *sar ~ tar* гэх мэт).

Монгол хэлний дорнод аялгуу нь хэлэлцэх хүний тоогоор төв аялгууны дараа хоёрдугаарт орох боловч энэ аялгуугаар хэлэлцэгчдийн нэлээд хэсэг нь хоёр хэлтэн, заримдаа холимог хэлтэн болж монгол үг, хэлээ нэлээд мартсан байна. Энэхүү дорнод аялгуугаар хэлэлцэгчид нь дотроо дан монгол хэлтэн, хоёр хэлтэн, холимог хэлтэн гэж гурав хуваагдахаас гадна авиан зүй, үгсийнхээ сангийн талаар бие биеэсээ ялгарах газар бий. Жишээлбэл, харчины аман аялгуунд *tš*-ээр хэлэх газар хорчины аман аялгуунд *š*-ээр (*tšayān ~ šayān*) мэт.

Тэмдэглэх нь, энд бид харь хэл мэдэхгүй, хоорондоо гагцхүү монгол үгээр хэлэлцэхийг дан монгол хэлтэн гэж, ерийн хэлэлцэхдээ хоорондоо дан монгол үгээр хэлэлцэж, харь хэлтэнтэй мөн харь үгээр хэлэлцэж чадахыг *хоёр хэлтэн* гээд, өөр зуураа цэвэр монгол хэлээр хэлэлцэж чадахгүй, харь хэлтэй хутган хэлэлцэх болсныг *холимог хэлтэн* гэж нэрлэв. Чингэхдээ энэ байдлыг уул нутгийн ерийн ардаар хэмжээ болгосон нь мэдээж хэрэг болно.

Дорнод аялгууг төв аялгуутай харьцуулан үзэхэд юуны өмнө мэдэгдэх гол гол онцлогууд нь хэрэв төв аялгуунд долоон эгшиг байдаг бол үүнээс дорнод аялгуунд *ó* эгшгийг бараг хэлэхгүй, дан ганц *ü*-ээр хэлнэ. Жишээлбэл, төв аялгууны *öndör* гэснийг *ündür* гэх мэт. Мөн төв аялгуунд *äë, öë*-гийн хос эгшгийг баахан урагшлуулсан *ä, ö*-тай хутган хэлдэг бол дорнод аялгуунд үүнийг гол төлөв үлэмж урагшилсан урт *ä, ö*-аар орлуулан хэлж, мөн төв аялгууны

ц, ʃ-ийн хос эгшгийг хэлний урдуурх урт $\bar{c}$, урагшлуулсан урт $\bar{c}$ -аар хэлнэ. Жишээлбэл, төв аялгууны $\bar{a}m\bar{a}g$, $\bar{o}$, $\bar{x}i\bar{l}$, $\bar{u}l$ гэснийг $\bar{a}m\bar{a}g$, $\bar{o}$, $\bar{x}i\bar{l}$, $\bar{u}l$ гэх мэт. Гийгүүлэгч авианы талаар бол төв аялгууны ts , $t\bar{s}$ гийгүүлэгчийг харчины аман аялгуунд мөн $t\bar{s}$ -аар хэлнэ. Хэлзүйн талаар бол төв аялгуунд байдаг үйл үгийн хувиллын зарим хэлбэр байдаггүй, мөн тийн ялгалын дагаврыг илрүүлэх авианы хэлбэр ялгавартай зэрэг болно.

Монгол хэлний өрнөд аялгуугаар Шинжааны ойрадууд, Ижил мөрний халимагууд хэлэлцэх бөгөөд эдний хүн амын тоо нийтдээ 160-аад мянга орчим болно. Үүнээс Шинжааны ойрадын аман аялгуугаар 60.000-аад хүн, Ижил мөрний ойрадын аман аялгуугаар 100.000-аад хүн хэлэлцэнэ. Өрнөд аялгууны аман аялгуунууд нь дотроо бас салбар аман аялгуунуудтай бөгөөд бас зарим хэсэгтээ хоёр хэлтэн, холимог хэлтэн болсон газар бий.

Өрнөд аялгууны төв аялгуунаасаа ялгарах гол гол онцлог гэвэл, авианзүйн талаар төв аялгууны $\bar{o}$, $\bar{u}$ -г $\bar{o}$, $\bar{u}$ гэж үлэмж урдуур хэлдэг, эгшиг авиа нь уруулаар зохицохгүй, хос эгшиг байхгүй болсон, эм ба саармаг эгшгийн өмнө тохиолдох шүргэх x гийгүүлэгчийг хамжих k -ээр хэлдэг, хэлзүйн талаар бол $-l\bar{a}$, $-l\bar{e}$ дагавартай холбох тийн ялгал байдаг зэргийг дурдаж болно.

Монгол хэлний умард аялгуугаар Байгалын урд, хойд биеэр нутаглах буриад монголчууд хэлэлцэх бөгөөд эдний хүн амын тоо нийтдээ 300.000 орчим болно.

Умард аялгуу нь дотроо Байгалын урд биеийн буриадын аман аялгуу, Байгалын хойд биеийн буриадын аман аялгуу гэж хоёр том бүлэгт хуваагдахаас гадна бас энэ хоёр аман аялгуу нь олон салбар аман аялгуу болж хуваагдана. Умард аялгуугаар хэлэлцэгчид нь гол төлөв хоёр хэлтэн болсон ба ялангуяа Байгалын хойд хэсгийн буриадууд нь холимог хэлтэн болсон байна. Умард аялгууны төв аялгуунаасаа ялгарах гол гол онцлог нь авианзүйн талаар төв аялгууны $\bar{o}$, $\bar{u}$ хоёр эгшгийг хутгах буюу гол төлөв $\bar{u}$ -ээр хэлэх болсон, нэгдүгээрээс хойших үеийн богино эгшгийг нэлээд тод хэлдэг, төв аялгууны, эгшгийн өмнө орсон s гийгүүлэгчийг төвөнгийн h -ээр, мөн үеийн эцэст орсон s -ийг d -ээр сольж хэлэх, халхын аман аялгууны ts -г s -ээр, $t\bar{s}$ -г $\bar{s}$ -ээр сольж хэлэх, мөн хамжин шүргэх dz , $d\bar{z}$ -ыг нь шүргэх z , $\bar{z}$ -ээр хэлэх, хэлзүйн талаар бол хэрэв төв аялгуунд үйлт нэр, нөхцөл үйл үг өгүүлэхүүн бүхий гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь харьяалах, заах заримдаа нэрлэхийн тийн ялгалаар байж болдог бол умард аялгуунд дан ганц харьяалахын тийн ялгалаар илрэх, цаг заах үйл үгийн өнгөрөн үргэлжилсэн цагийн хэлбэр бараг байхгүй болсон, үйлт нэрийн өнгөрөн үргэлжилсэн цагийн хэлбэрийг цагийг заах үйл үгийн өнгөрсөн цагийн утгаар хэрэглэх болсон, болзох нөхцөл үйл үгийн янз бүрийн хэлбэр байхгүй болж оронд нь $-h\bar{a}$ гэдэг дагавар үгийг хэрэглэх болсон, тогтворгүй n -аар төгссөн үг нь нэрлэхийн тийн ялгалын хэлбэрт уул n нь гээгдэхгүй зэрэг болно.

Монгол хэлний дорнод, өрнөд, умард аялгууг үгсийн нь сангийн талаар төв аялгуутай харьцуулан үзвэл бас л их ойрхон юм. Үүнд нөхөр Чингэлтэйн мэдээгээр үзвэл дорнод аялгууны хорчины аман аялгууны өргөн хэрэгцээний 9458 үгээс монгол бичгийн хэл буюу төв аялгууны халхын аман аялгууны үгстэй утга ба авиагаараа яг тохирох үгс 19.4%, зөвхөн авианы зөрөөтэй үгс 62%, адил бус үгс 13.3%, дорнод аялгууны харчины аман аялгууны өргөн хэрэгцээний 6837 үгээс халхын аялгууны үгстэй утга ба авиагаараа яг тохирох үгс 37%, зөвхөн авианы зөрөөтэй үгс 47.7%, адил бус үгс 12% байсан ба умард аялгууны Байгалын зүүн биеийн буриадын аман аялгуунд хамаарагдах бөгөөд одоо Хөлөнбуйрт бөөнөөрөө сууж угийн буриадын аялгуугаа цэврээр хадгалсаар бүхий буриадуудын өргөн хэрэгцээний 8370 үгээс халхын аман аялгууны үгстэй утгаар, авиагаараа яг тохирох үгс 68%, зөвхөн авианы зөрөөтэй үгс 25.8%, адил бус үгс 1% байжээ. Мөн өрнөд аялгууны Шинжааны ойрадын аман аялгууны үгсийн сангийн ихэнх үгс нь монгол утга зохиолын хэлний үгстэй тохирох ба адил бус үгс дөнгөж 5%-ийг эзэлнэ гэж тэмдэглэжээ.

Орчин цагийн монгол хэлний завсрын аман аялгуунуудыг ажиглавал дээр дурдсан дөрвөн үндсэн аялгууны алинд нь ч байхгүй тийм биеэ даасан онцлоггүй, зөвхөн төв аялгуу, зах хязгаарынхаа аль нэг аялгуутай хутгалдсан байдалтай ажээ. Жишээлбэл, төв ба умард аялгууны завсрын аман аялгуу болох Сэлэнгийн аман аялгуу нь авианыхаа системээр халхын аман аялгуутай бараг адил боловч үгсийнхээ сангийн талаар буриадын аялгуутай нэлээд ойролцоо ба мөн баргын аман аялгуу нь авианыхаа системээр умард аялгуутай төсөөтэй зүйл үзэгдэвч үгсийнхээ сангийн талаар халхын аман аялгуутай маш ойрхон болсон байна.

Үүнд нөхөр Чингэлтэйн мэдээнээс үзвэл хуучин баргын өргөн хэрэгцээний 8701 үгээс монгол бичгийн хэл буюу халхын аман аялгууны үгстэй утга ба авиагаараа яг тохирох үгс 73%, зөвхөн авианы зөрөөтэй үгс 26%, адил бус үгс 2.5%, шинэ баргын өргөн хэрэгцээний 9185 үгээс халхын аман аялгууны үгстэй утга ба авиагаараа яг тохирох үгс 74%, зөвхөн авианы зөрөөтэй үгс 23%, адил бус үгс 0.42% байжээ. Барга нарын хэлэлцэх аялгуу нь халхын аман аялгуунаас бараг ялгаваргүй бөгөөд эдний үг хэлийг халхын аман аялгууны салбар аман аялгуу гэмээр сэтгэгдэл төрүүлнэ.

Төв ба дорнод аялгууны завсрын аман аялгуунууд болох *баарин*, *ар хорчин*, *найман*, *онниудын аман аялгуунууд* нь авианзүйнхээ шинж байдлаар дорнод аялгуунд ойр зүйл нэлээд бий боловч үгсийн баялаг, ялангуяа монгол хэлнийхээ онцлогийг хадгалснаараа төв аялгуундаа их л ойр ажээ. Үүнд нөхөр Чингэлтэйн мэдээнээс үзвэл дурдсан аман аялгуунуудын өргөн хэрэгцээний 10460 үгээс монгол утга зохиолын хэл буюу халхын аман аялгууны үгстэй утга ба авианыхаа талаар яг адил үгс 37%, зөвхөн авианы зөрөөтэй үгс 57.7%, адил бус үгс дөнгөж 3.7% байжээ. Энэ аман аялгуунуудад *о*, *й* хоёрыг ялгах, хорчины аман аялгууны *й*-ээр хэлэх газар ихэнхдээ *й*-ээр хэлэх мэтчилэн төв аялгууны цахар аман аялгуутай ойртох газар арвин үзэгдэнэ.

Төв ба өрнөд аялгууны завсрын аман аялгуунууд болох *Хөхнуур*, *Эзнээ гол*, *Алшаа*, *Ховдын ойрадуудын аман аялгуунууд* нь авианзүй, хэлзүйнхээ шинж байдлаар утгаа Өрнөд Шинжаан, Ижил мөрний ойрадын аялгуутай нэг гаралтай боловч сүүлийн хэдэн зуун жилийн турш төв аялгуугаар хэлэлцэх *халх*, *цахар*, *ордос*, *урад* зэрэг төв монголчуудтайгаа нягт холбоотой явж ирсэн тул тэдний үг хэлэнд төв аялгууны нөлөө улам улам нэвтэрч, ялангуяа үгсийн сангийнхаа талаар төв аялгуутай их л ойр болсон байна. Нөхөр Чингэлтэйн мэдээнээс үзвэл *Хөхнуурын аман аялгуунд о, й-г о, и-тай хутган хэлдэг болсон*, хааяа хос эгшиг үзэгддэг, үгсийн сангийнхаа талаар бол *Алшаагийн ойрадын өргөн хэрэгцээний 7371 үгээс монгол утга зохиолын хэл буюу халхын аман аялгууны үгстэй утга ба авиагаараа яг тохирох үгс 21.7%*, зөвхөн авианы зөрөөтэй үгс 72.7%, адил бус үгс 2.7%, *Эзнээ голын ойрадын өргөн хэрэгцээний 9413 үгээс халхын аман аялгууны үгстэй утга ба авиагаараа яг тохирох үгс 36.8%*, зөвхөн авианы зөрөөтэй үгс 37.6%, адил бус үгс 4% байжээ. *Ховдын ойрадуудын үг хэл нь үгсийн сангийнхаа талаар халхын аман аялгуутай их ойртсон ба залуу үеийн хүмүүс нь цэвэр халхын аман аялгуугаар хэлэлцэх болсон нь арвин үзэгдэнэ.*

Орчин цагийн монгол хэл, аялгууны ерөнхий байдал, түүний олон нутгийн аялгуу, аман аялгууны хоорондын харьцаа ийм байна. Монгол хэлний олон нутгийн аялгуугаар хэлэлцэгчид буюу өөрөөр хэлбэл, ар, өвөр монголчууд, ойрад, буриадуудын хоорондын харилцаа нь сүүлийн тавиад жилийн дотор бие биеэсээ тасарсангүйгээр үл барам ялангуяа орос, хятад хоёр их үндэстний нийгмийн байдалд хувьсгалын их өөрчлөлт гарч Хятад, Оросын ард түмний хооронд мөнхийн найрамдал тогтсон явдалтай холбогдон, мөн Монгол-Орос, Монгол-Хятадын ард түмнүүдийн хооронд ах дүүгийн найрамдал бэхэжсэн төдийгүй, мөн монгол угсаатны хоорондын соёлын харилцаа ч нэгэн адил өргөжиж, хэл аялгууныхаа талаар бие биедээ нөлөөлөх явдал өнгөрсөн үетэй адилтгашгүй хүчтэй болж байна.